



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/101/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор хот 2023 оны 01 дүгээр сар</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН
ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Н.БЯМБАДОРЖ ТАНАА

2023.01.31 № 2/02

танай _____ -ны № _____ -т

Г _____ Г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022.11.23-ны өдрийн 417 дугаар "Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2022.12.31-ны өдрөөр тасалбар болгон татан буулгасантай холбоотойгоор Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагаа 2022 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болж тайлангаа гаргасан. Байгууллагын хаалтын баланс гараагүй байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2022.11.23-ны өдрийн 417 дүгээр тогтоолын 2.3-д заасны дагуу Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газар ажиллаж байгаа улсын ахлах байцаагч, улсын байцаагч нарыг аймгийн ЗДТГ, Байгал орчин аялал жуулчлалын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Мал эмнэлгийн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний

· 005020104

газар, Эрүүл мэндийн газар, Стандарт хэмжил зүйн газарт ашиглаж буй компьютер, техник хэрэгслийн хамт шилжүүлэн ажиллах тушаал гарсан байна.

Бусад асуудлын хэсэг

Дээрх тогтоолтой холбогдуулан тус газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх, авто тээврийн хэрэгсэл, бусад хөрөнгийг талаар эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is slanted upwards from left to right.

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	123,108,552.38	69,567,889.41
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,749,826.00	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	10,749,826.00	0.00
3121	Төгрөг	10,749,826.00	0.00
31211	Төрийн сангийн харилцах	10,749,826.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	112,358,726.38	69,567,889.41
351	Түүхий эд материал	32,327,326.27	35,640,910.17
35110	Тусгай зориулалттай материал	10,261,904.48	11,121,984.48
35130	Эм боох материал	22,065,421.79	24,518,925.69
354	Хангамжийн материал	80,031,400.11	33,926,979.24
35410	Бичиг хэргийн материал	8,033,578.89	2,082,923.89
35420	Аж ахуйн материал	31,035,457.00	9,754,217.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,308,150.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	2,375,161.20	0.00
35470	Бусад хангамжийн материал	37,279,053.02	22,089,838.35
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,401,822,436.24	1,432,369,380.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,401,822,436.24	1,432,369,380.57
392	Биет хөрөнгө	1,326,118,525.90	1,357,711,678.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,296,852,003.00	1,296,852,003.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-93,542,569.76	-124,683,800.33
39203	Авто-тээврийн хэрэгсэл	78,538,000.00	151,538,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-38,701,943.50	-48,230,317.80
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	296,802,772.00	332,927,854.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-230,304,080.51	-265,285,453.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,834,399.00	38,832,249.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-30,701,758.69	-33,247,829.88
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,803,200.00	14,803,200.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,461,495.64	-5,794,225.24
393	Биет бус хөрөнгө	75,703,910.34	74,657,701.60
39301	Програм хангамж	1,262,200.00	1,262,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,213,318.83	-1,238,843.28
39303	Бусад биет бус хөрөнгө	82,845,000.00	82,845,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-7,189,970.83	-8,210,655.12
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,524,930,988.62	1,501,937,269.98
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,524,930,988.62	1,501,937,269.98
51	Засгийн газрын хувь оролцоо	1,524,930,988.62	1,501,937,269.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,087,914,987.82	1,087,914,987.82
51101	Өмч: - төрийн	1,087,914,987.82	1,087,914,987.82
512	Хуримтлагдсан үр дүн	-45,100,585.61	-68,094,304.25
51210	Өмнөх үеийн үр дүн	-4,451,273.17	-45,100,585.61
51220	Тайлант үеийн үр дүн	-40,649,312.44	-22,993,718.64
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	482,116,586.41	482,116,586.41
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,524,930,988.62	1,501,937,269.98

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	824,765,304.50	891,318,282.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,833,804.50	109,771,782.00
120	Нийтлэг татварын бус орлого	31,833,804.50	109,771,782.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	27,833,804.50	109,771,782.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,458,000.00	12,817,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	90,000.00	96,675,282.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	6,285,804.50	278,700.00
120009	Бусад орлого	4,000,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	792,931,500.00	781,546,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	791,948,500.00	780,476,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	791,948,500.00	780,476,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	983,000.00	1,070,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	878,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,000.00	70,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	865,414,616.94	914,312,000.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	865,414,616.94	914,312,000.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	813,269,325.33	859,168,220.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	493,283,695.32	523,812,226.82
210101	Үндсэн цалин	349,581,124.32	348,045,831.87
210102	Нэмэгдэл	118,565,173.00	131,209,694.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,918,500.00	27,896,796.00
210104	Урамшуулал	9,218,898.00	16,659,904.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,684,354.07	65,056,813.19
210201	Тэтгэврийн даатгал	44,272,253.47	45,379,585.88
210202	Тэтгэмжийн даатгал	4,919,960.64	5,338,774.81
210203	ҮОМШ өвчний даатгал	3,941,033.48	4,220,619.85
210204	Ажилгүйдлын даатгал	868,282.61	919,802.97
210205	Эрүүл мэндийн даатгал	8,682,823.87	9,198,029.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,071,167.00	63,231,946.00
210301	Гэрэл цахилгаан	2,985,295.00	3,360,114.00
210302	Түлш, халаалт	50,935,312.00	50,935,312.00
210303	Цэвэр, бохир ус	7,150,560.00	8,936,520.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,483,215.78	63,531,996.22
210401	Бичиг хэрэг	7,041,440.00	14,867,555.00
210402	Тээвэр, шатахуун	18,275,803.00	19,808,161.20
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	6,057,252.00	6,197,300.44
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,280,825.00	5,580,628.40
210408	Бараа материал акталсны зардал	327,895.78	16,478,351.18
2105	Нормативт зардал	8,204,066.94	4,850,361.92
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,576,066.94	2,085,656.92
210502	Хоол, Хүнс	4,628,000.00	2,764,705.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,755,576.88	27,010,124.27
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	14,662,626.88	20,480,774.27
210604	Урсгал засвар	20,092,950.00	6,529,350.00

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	20,596,800.00	17,164,100.00
210702	Дотоод албан томилолт	20,596,800.00	17,164,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,450,660.00	7,670,814.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,047,100.00	2,008,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,136,900.00	1,795,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,551,700.00	2,670,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	163,460.00	338,464.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	66,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	198,000.00	492,000.00
210807	Газрын төлбөр	298,500.00	298,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,739,789.34	86,839,837.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	3,462,700.00
210902	Хичээл үйлвэрлэлийн дадлага хийх	1,006,600.00	1,659,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	81,733,189.34	81,718,137.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,145,291.61	55,143,780.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,440,380.00	34,884,726.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,300,000.00	10,749,826.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,290,380.00	23,144,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,850,000.00	990,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,704,911.61	20,259,054.55
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,830,411.61	7,441,254.55
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэн шилжүүлэг	20,874,500.00	12,817,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-40,649,312.44	-22,993,718.64
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-40,649,312.44	-22,993,718.64

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
0	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	818,389,500.00	794,364,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,458,000.00	12,817,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	25,458,000.00	12,817,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,458,000.00	12,817,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,458,000.00	12,817,800.00
120009	Бусад орлого	4,000,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	792,931,500.00	781,546,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	791,948,500.00	780,476,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	791,948,500.00	780,476,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	983,000.00	1,070,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	878,000.00	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,000.00	70,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	803,464,880.00	789,524,326.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	803,464,880.00	789,524,326.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	751,319,588.39	734,380,545.45

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	493,283,695.32	523,812,226.82
210101	Үндсэн цалин	349,581,124.32	348,045,831.87
210102	Нэмэгдэл	118,565,173.00	131,209,694.95
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	15,918,500.00	27,896,796.00
210104	Урамшуулал	9,218,898.00	16,659,904.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,684,354.07	65,056,813.19
210201	Тэтгэврийн даатгал	44,272,253.47	45,379,585.88
210202	Тэтгэмжийн даатгал	4,919,960.64	5,338,774.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,941,033.93	4,220,619.85
210204	Ажилгүйдлийн даатгал	868,282.61	919,802.97
210205	Эрүүл мэндийн даатгал	8,682,823.42	9,198,029.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,071,167.00	63,231,946.00
210301	Гэрэл, цахилгаан	2,985,295.00	3,360,114.00
210302	Түлш, халаалт	50,935,312.00	50,935,312.00
210303	Цэвэр, бохир ус	7,150,560.00	8,936,520.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,507,472.00	31,848,075.44
210401	Бичиг хэрэг	7,173,400.00	6,026,200.00
210402	Тээвэр, шатахуун	16,852,400.00	17,433,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,057,252.00	6,197,300.44
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500,000.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,924,420.00	1,591,575.00
2105	Нормативт зардал	17,839,400.00	10,722,620.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,686,400.00	8,217,820.00
210502	Хоол, хүнс	4,628,000.00	2,504,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	525,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	44,285,440.00	6,721,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	25,634,340.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	18,651,100.00	5,221,200.00
2107	Томилолт, зочны зардал	20,596,800.00	17,164,100.00
210702	Дотоод албан томилолт	20,596,800.00	17,164,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,044,660.00	10,561,514.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,047,100.00	4,008,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,136,900.00	1,795,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,551,700.00	2,670,950.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	163,460.00	338,464.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	66,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,503,000.00	1,284,000.00
210807	Газрын төлбөр	298,500.00	298,500.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	289,000.00	98,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,006,600.00	5,262,050.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	3,462,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,006,600.00	1,799,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,145,291.61	55,143,780.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,440,380.00	34,884,726.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	4,300,000.00	10,749,826.00

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,290,380.00	23,144,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,850,000.00	990,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,704,911.61	20,259,054.55
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,830,411.61	7,441,254.55
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэн шилжүүлэг	20,874,500.00	12,817,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,924,620.00	4,839,974.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	15,224,620.00	15,589,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,224,620.00	15,589,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,224,620.00	15,589,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,224,620.00	15,589,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-15,224,620.00	-15,589,800.00
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-300,000.00	-10,749,826.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,049,826.00	10,749,826.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,749,826.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
4-01	2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,087,914,987.82	482,492,886.41	-4,827,573.17	1,565,580,301.06
4-02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,087,914,987.82	482,492,886.41	-4,827,573.17	1,565,580,301.06
4-04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	376,300.00	-376,300.00	0.00
4-08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-40,649,312.44	-40,649,312.44
4-01	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,087,914,987.82	482,116,586.41	-45,100,585.61	1,524,930,988.62
4-02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
4-03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,087,914,987.82	482,116,586.41	-45,100,585.61	1,524,930,988.62
4-08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-22,993,718.64	-22,993,718.64
4-01	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,087,914,987.82	482,116,586.41	-68,094,304.25	1,501,937,269.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	780,476,500.00	773,035,245.45	7,441,254.55	99.0
УРСГАЛ ЗАРДАЛ	780,476,500.00	773,035,245.45	7,441,254.55	99.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	757,031,600.00	749,590,345.45	7,441,254.55	99.0
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	529,739,800.00	523,812,226.82	5,927,573.18	98.9
Үндсэн цалин	349,612,100.00	348,045,831.87	1,566,268.13	99.6
Нэмэгдэл	132,296,700.00	131,209,694.95	1,087,005.05	99.2

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Унаа хоолны Хөнгөлөлт	28,314,000.00	27,896,796.00	417,204.00	98.5
Урамшуулал	19,517,000.00	16,659,904.00	2,857,096.00	85.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,217,500.00	65,056,813.19	1,160,686.81	98.2
Тэтгэврийн даатгал	45,027,900.00	45,027,900.00	0.00	100.0
Тэтгэмжийн даатгал	5,297,400.00	5,297,400.00	0.00	100.0
ҮОМШӨ-ний даатгал	4,237,900.00	4,220,619.85	17,280.15	99.6
Ажилгүйдлийн даатгал	1,059,500.00	955,608.43	103,891.57	90.2
Эрүүл мэндийн даатгал	10,594,800.00	9,555,284.91	1,039,515.09	90.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	63,175,200.00	63,081,446.00	93,754.00	99.9
Гэрэл, цахилгаан	3,303,200.00	3,209,614.00	93,586.00	97.2
Түлш, халаалт	50,935,400.00	50,935,312.00	88.00	100.0
Цэвэр, бохир ус	8,936,600.00	8,936,520.00	80.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	31,764,800.00	31,740,775.44	24,024.56	99.9
Бичиг хэрэг	5,956,200.00	5,956,200.00	0.00	100.0
Тээвэр, шатахуун	17,433,000.00	17,433,000.00	0.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,169,700.00	6,160,000.44	9,699.56	99.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	600,000.00	0.00	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,605,900.00	1,591,575.00	14,325.00	99.1
Нормативт зардал	10,722,700.00	10,722,620.00	80.00	100.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,217,900.00	8,217,820.00	80.00	100.0
Хоол, хүнс	2,504,800.00	2,504,800.00	0.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	22,352,700.00	22,311,000.00	41,700.00	90.0
Багаж, техник, хэрэгсэл	4,202,100.00	4,189,800.00	12,300.00	99.7
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	9,900,000.00	9,900,000.00	0.00	100.0
Урсгал засвар	8,250,600.00	8,221,200.00	29,400.00	99.6
Томилолт, зочны зардал	17,302,800.00	17,164,100.00	138,700.00	99.2
Дотоод албан томилолт	17,302,800.00	17,164,100.00	138,700.00	99.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,456,100.00	10,402,014.00	54,086.00	99.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,849,000.00	3,849,000.00	0.00	100.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,795,900.00	1,795,900.00	0.00	100.0
Даатгалын үйлчилгээ	2,670,700.00	2,670,700.00	0.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	366,600.00	338,714.00	27,886.00	92.4
Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	66,500.00	21,500.00	75.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,284,000.00	1,284,000.00	0.00	100.0
Газрын төлбөр	298,500.00	298,500.00	0.00	100.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	103,400.00	98,700.00	4,700.00	95.5
Бараа үйлчилгээний бусад зардал	5,300,000.00	5,299,350.00	650.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	3,500,000.00	3,500,000.00	0.00	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	1,800,000.00	1,799,350.00	650.00	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,444,900.00	23,444,900.00	0.00	100.0
Бусад урсгал шилжүүлэг	23,444,900.00	23,444,900.00	0.00	100.0
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.00	0.00	0.00	0.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	23,144,900.00	23,144,900.00	0.00	100.0

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00	0.00	100.0
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	780,476,500.00	780,476,500.00	0.00	100.0
Улсын төсвөөс санхүүжих	780,476,500.00	780,476,500.00	0.00	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.0
Ажиллагсад бүгд	39.00	38.00	0.00	97.4
Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.0
Гүйцэтгэх ажилтан	24.00	23.00	0.00	97.4
Үйлчлэх ажилтан	14.00	14.00	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/төгрөгөөр/	
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
	Мөнгөн хөрөнгийн 2022 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл		-	
I	ОРЛОГЫН ДҮН	-	1,070,000.00	
	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,000,000.00	
	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		70,000.00	
II	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	0.00	1,070,000.00	
	А. УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	1,070,000.00	
	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	380,000.00	
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	150,500.00	
	Гэрэл, цахилгаан		150,500.00	
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	229,500.00	
	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	229,500.00	
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	690,000.00	
	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	690,000.00	
	Мөнгөн хөрөнгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний	0.00	0.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Хяналт шалгалтын үйл ажиллагаанд дижитал шилжилт хийж, хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлнэ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон. Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 417 дугаар "Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолоор Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2022.12.31-ны өдрөөр тасалбар болгон татан буулгах шийдвэр гарсантай холбогдуулан Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааг 2022.12.31-ны өдрөөр тасалбар болгосон.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

МХЕГ нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь МХЕГ-аас 2016 онд боловсруулсан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад

мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,501,937.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 22,993.7 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10,749.8	-	(10,749.8)
Авлага			
Бараа материал	112,358.7	69,567.9	(42,790.8)
Үндсэн хөрөнгө	1,401,822.4	1,432,369.4	30,546.9
Нийт хөрөнгө	1,524,931.0	1,501,937.3	(22,993.7)
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,524,931.0	1,501,937.3	(22,993.7)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,524,931.0	1,501,937.3	(22,993.7)

Эх сурвалж: 2022 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 10,749.8 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангийн дансны үлдэгдлийг ахмад настнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт, ахмадын баяр, цагаан сарын баяраар хүндэтгэл үзүүлэх, санхүүгийн дэмжлэг олгож бүрэн зарцуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 69,567 мянган төгрөг болж 42,790.8 мянган төгрөгөөр буурсан нь 12,421.1 мянган төгрөгийн аж ахуйн материал, 2,730.0 мянган төгрөгийн эм боох материал, 177.3 мянган төгрөгийн тусгай зориулалтын материалыг байгууллагын эхний хагас жилийн болон жилийн эцсийн тооллогоор газрын даргын зөвлөлийн хурлын шийдвэрээр акталж, бусад хангамжийн материал 16,823.2 мянга, бичиг хэргийн материал 5,950.6 мянган төгрөгөөр буурсан нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,432,369.4 мянган төгрөг болж 30,546.9 мянган төгрөгөөр өссөн нь МХЕГ-ын даргын 2022.5.10 -ны өдрийн А/21 тушаалаар 20,900.0 мянган төгрөгийн агаарын бохирдлын агууламж хэмжигч багаж, Засгийн газрын 2022.11.16-ны өдрийн 407 дугаар тогтоолоор улсын нөөцөөс 70,000.0 мянган төгрөгийн УА3330695-550 фургон суудлын автомашиныг үнэ төлбөргүй орлого авч, төсвийн хөрөнгөөр 15,589.8 мянган төгрөгийн хөрөнгөөр худалдан авч, ТӨБЗГ-ын 2022.05.03-ны өдрийн 190 тогтоолын үндэслэн газрын даргын 2022.06.06-ны өдрийн А/28 дугаар тушаалаар 4,750.0 мянган төгрөгийн хөрөнгийн өртөг нэмэх, ашиглалтын хугацаа сунгаж тус тус орлогоор бүртгэснээс шалтгаалсан байна.

ТӨБЗГ-ын 2022.05.19-ны өдрийн 247 тогтоолыг үндэслэн газрын даргын 2022.06.06-ны өдрийн А/29 дүгээр тушаалаар 142.1 мянган төгрөгийн хөрөнгө акталсан.

Тайлант онд авлага, өр төлбөрийн үлдэгдэл байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,501,937.3 мянган төгрөг болж 22,993.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 22,993.7 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,108,782.5 мянга, нийт зарлагыг 1,108,782.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин, НДШ-ийн зардлыг 233,475.9 мянган, эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлыг 7,136.1 мянга, багаж техник хэрэгсэл, тавилга эд хогшил худалдан авах зардлыг 97,130.8 мянга, томилолтын зардлыг 9,652.7 мянган төгрөгөөр тус тус бууруулж, 742,111.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь орон тоог 50 орон тоогоор ажиллахаар төлөвлөснөөс 39 орон тоогоор ажиллахаар, Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоогоор тавилга эд хогшил худалдан авахгүй байх зэргээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 742,111.9 мянган төгрөгийн төсөв баталсныг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант оны батлагдсан төсвийг нийт 9 удаа тодотгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 780,476.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, өөрийн орлогоор 7000.0 мянган төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөг баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 780,476.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, лаборатори шинжилгээний орлого 12,817.8 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 773,035.2 төгрөг буюу 99 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 7,440.6 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Биелэлт
ХӨТӨЛБӨР 70417- Мэргэжлийн хяналт	780,476.5	773,035.2	7,441.3	99
АРГА ХЭМЖЭЭ 80101 -Үндсэн үйл ажиллагааны зардал	755,231.6	747,791.0	7,440.6	99.8
АРГА ХЭМЖЭЭ 80205- Мэдээлэл сурталчилгааны зардал	840.5	840.5	0.0	100
АРГА ХЭМЖЭЭ 80227-Лабораторийн итгэмжлэл	1008.5	1008.5	0.0	100
АРГА ХЭМЖЭЭ 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардал	23,444.9	23,444.9	0.0	100

Эх сурвалж:2022 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2022.02.25-ны өдрийн А/102 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээгээр “Тусгай” байранд шалгарч 1,000.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал, цахим тендерийн орлогоор 70.0 төгрөг нийт 1,070.0 мянган төгрөгийг албан хаагчдын нийгмийн асуудалд 690.0 мянга, 310.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл хөтөлбөр байхгүй байна..

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/367 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны нийт зардлыг сонгож материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 914,312.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,714.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 9,600.3 мянган тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн нийт 15150.7 мянган төгрөгийг ашиглалтын зардал, албан томилолт, бичиг хэргийн зардлаас хэмнэсэн байна. Үүнд

Энэ хуулийн хүрээнд Томилолтын зардлыг анх 29596.8 мянган төгрөгийн төсөв баталсан ба тодотголоор 12,294.0 мянган төгрөгийг хасаж 17302.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 17,164.1 мянган төгрөг зарцуулсан.

Ашиглалтын зардлыг анх 63505.6 мянган төгрөгөөр баталснаас тодотголоор 330.4 мянган төгрөгөөр бууруулан баталсан. Гүйцэтгэлээр 63081.4 мянган төгрөг зарцуулсан.

Бичиг хэргийн зардлыг анх 8250.0 мянган төгрөгөөр баталснаас тодотголоор 2293.8 мянган төгрөгөөр бууруулж 5956.2 мянган төгрөгөөр баталсныг бүрэн зарцуулсан

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тендер шалгаруулах худалдан авах ажиллагаа-1, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 1037,339.8 мянган төгрөгийн 14 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 79,305.5 мянган төгрөгийн 9 гүйлгээ, өмч хөрөнгөтэй холбоотой 65,254.9 мянган төгрөгийн 18 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн* гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 4500,0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлэн биелэлтийг 2022.05.30-ны өдрийн 01/159 дугаар албан бичгээр хүргүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	4500.0	2.	4500.0	100
Нийт дүн	2	4500.0	2.	4500.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2022.11.23-ны өдрийн 417 дүгээр тогтоолын 2.3-д заасны дагуу Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газар ажиллаж байгаа улсын ахлах байцаагч, улсын байцаагч нарыг аймгийн ЗДТГ, Байгал орчин аялал жуулчлалын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Мал эмнэлгийн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар, Стандарт хэмжил зүйн газарт ашиглаж буй компьютер, техник хэрэгслийн хамт шилжүүлэн ажиллах тушаал гарсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022.11.23-ны өдрийн 417 дүгээр тогтоолыг үндэслэн дээрх албан байгууллагуудад улсын байцаагчийн эд хариуцагчийн картад байгаа 531 ширхэг 356,101.0 мянган төгрөгийн хөрөнгө, 33588 ширхэг 69,597.9 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг хөрөнгө хүлээлцсэн актаар 2022.12.30-д хүлээлгэн өгсөн.

Тус газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга,нийтийн эзэмшлийн хөрөнгө, газар авто тээврийн хэрэгсэл зэрэг 1,541,621.3 мянган төгрөгийн хөрөнгө, актлах

хүсэлт гаргасан 711 ширхэг 20,046.0 мянган төгрөгийн хөрөнгө, 1,262.2 мянган төгрөгийн санхүүгийн программ хангамжийг хэрхэх талаар эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байна.

Хөдөлмөрийн гэрээ дуусгавар болж буй 11 албан хаагчдад газрын даргын 2022.12.28-ны өдрийн Б/90-Б/100 хүртэл тушаалаар 3-6 сарын цалинтай тэнцэх нэг удаагийн мөнгөн тэтгэмж 37681.3 мянга, МХЕГ-ын даргын 2022.12.30-ны өдрийн Б/508 дугаар тушаалаар газрын дарга Н.Бямбадоржид 3 сарын цалинтай тэнцэх нэг удаагийн мөнгөн тэтгэмж 4,637.7 мянган төгрөг нийт 42,499.0 мянган төгрөгийн нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор тушаал гарсан боловч санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---oOo---